

II БҮЛЭГ.ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагчийн нэр: Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТШЗ 1.1	Зарлалын дугаар: СЭМУТ/20240202007 Тендер шалгаруулалтын нэр: Цэвэрлэгээний бараа, материал, хог хаягдлын уут, аюулгүй хайрцаг худалдан авах Тендер шалгаруулалтын багцын тоо болон нэр: Багцтай Багц 1: Цэвэрлэгээний материал, хог хаягдлын уут худалдан авах Багц 2: Аюулгүйн хайрцаг худалдан авах
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр: Төсвийн хөрөнгөөр Нийт төсөвт өртөг: 85,000,000 төгрөг <i>Багц 1: Цэвэрлэгээний материал, хог хаягдлын уут худалдан авах - 73,090,000 төгрөг</i> <i>Багц 2: Аюулгүйн хайрцаг худалдан авах -11,910,000 төгрөг</i>
Б.АГУУЛГА	
ТШЗ 9.2	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хариуцсан ажилтан: Халдвар судлаач эмч Г.Дайриймаа Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 34 дүгээр хороо, 50 дугаар гудамж Утасны дугаар: 11-458298, 99133069 Цахим шуудан: ncmh@ncmh.gov.mn dairiidairii94@gmail.com
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнө уулзалт зохион байгуулах эсэх: “ҮГҮЙ”
В.ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.2	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл.
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “ЗӨВШӨӨРӨХГҮЙ”
ТШЗ 16.2	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг: “Шаардана” 1. Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэл болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ. 2. Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй хүчин төгөлдөр лавлагааг цахим системээс авч, зааварчилгааны дагуу цахим системээр ирүүлнэ. Үүнд: - Шүүхийн тусгай архивын лавлагаа, - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт -Тендерт оролцогч нь Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг илгээх бөгөөд холбогдох байгууллагууд нь лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу. <p align="center"><i>Жич: Дээрх лавлагаа авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу.</i></p>

	Энэхүү тодорхойлолтуудыг ирүүлээгүй тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: Шаардана.</p> <ul style="list-style-type: none"> - <i>Борлуулалтын орлогын хэмжээ: 2022, 2023 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх.</i> - <i>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ нь багадаа төсөвт өртгийн 50 хувийг хангахуйц байх</i> - <i>Банк санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшхи өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх</i>
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогчийн борлуулалтын орлогын мэдээллийг Сангийн яамны санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангаас шалгана. 2. Түргэн хөрвөх хөрөнгийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тодорхойлно. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Тендерт оролцогчийн харилцагч банкны дансны үлдэгдэл / тендер зарласан цаг хугацаанд хамаарах/ - Харилцагч банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт / тендер зарласан цаг хугацаанд хамаарах/ - 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн ТХЧХ /ТХЧД болон авах боломжтой зээлийн дүнг Сангийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн загвар”-ын 3.2.2 /е/-д заасны дагуу тодорхойлно/. <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн чадварыг зөвхөн дээр дурьдсан 3 баримтаар нотлох бөгөөд бусад төрлийн нотолгоог үнэлгээнд хүлээн зөвшөөрөхгүй буюу шаардлага хангаагүй гэж үзнэ.</p> <ol style="list-style-type: none"> 3. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн бус” байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолтыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендер үнэлэхэд харгалзан үзэхгүй /зөвхөн цахим лавлагааг үндэслэнэ./
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлага: “Шаардана”</p> <ol style="list-style-type: none"> 1. Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлага: Шаардана. Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 онуудад доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн байх бөгөөд ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний хуулбар, хүлээлгэж өгсөн актын хуулбар, тухайн барааг цаг хугацаанд нь чанартай нийлүүлсэн талаарх захиалагчийн тодорхойлолт ирүүлэх

	2. Ижил төстэй бараа нийлүүлтэд тухайн бараа болон түүнтэй дүйцэхүйц бараа нийлүүлсэн туршлагыг тооцно.
ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын танилцуулга. 2. Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн толдрхойлолтыг харьцуулсан байдлаар дэлгэрэнгүй танилцуулга, хүснэгтээр бэлтгэж баталгаажуулж ирүүлнэ. <p>Техникийн чадавх болон туршлагын талаар заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлоход шаардлагатай бусад баримт:</p> <ol style="list-style-type: none"> 1. Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг ирүүлнэ. 2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар ирүүлэх. 3. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захилагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр ирүүлэх 4. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид захиалгын дагуу тасралтгүй нийлүүлэх /365 хоногт/ баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.
ТШЗ 19.3	<p>Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ шаардлагатай эсэх: "Үгүй"</p> <p>Харин тухайн барааны захиалга хүлээн авалт, нийлүүлэлт, гүйцэтгэлийг хариуцсан баг ажиллуулах бөгөөд багийн танилцуулга, ажиллах хүчний хуваарилалт, бараа нийлүүлэлтийн төлөвлөгөө боловсруулан, баталгаажуулж ирүүлэх.</p>
ТШЗ 21.1	<p>Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээний талаарх мэдээлэл ирүүлэх эсэх: "ҮГҮЙ"</p> <p>Тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгатай холбоотой зааварчилгаа, мэдээлэл ирүүлэх эсэх: "ҮГҮЙ"</p>
ТШЗ 22.2	Оролцогчийн санал болгосон тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: "ТОХИРУУЛАХГҮЙ"
ТШЗ 22.3	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: "ҮГҮЙ"
Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ	
ТШЗ 25.4	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хуулийн 7 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлага хангасныг нотлох баримт бичиг 2. Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн мэдээлэл 3. Хуульд заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл байгаа бол хууль зүйн үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл
ТШЗ 26.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Огноо: 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут</p>